

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ МАНДАЛГОВЬ ХОТОД БАРИГДАХ 20 ГКАЛ/Ц ХҮЧИН
ЧАДАЛТАЙ ДУЛААНЫ СТАНЦ, 9.222 М ШУГАМ ХООЛОЙ, 8 ТҮГЭЭХ ТӨВҮҮДИЙГ
БАРЬЖ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5638089/

ХЯНАСАН:

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

.....

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“БЬЮКСАН ИНЖЕНЕРИНГ”

компаний захирал

ЧОЙ САНГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“БЬЮКСАН ИНЖЕНЕРИНГ” компанийн

ХАБЭАБО хариуцсан менежер

А.АНДБАЯР

ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дундговь аймгийн Мандалговь хотод баригдах 20 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц, 9.222 метр шугам хоолой, дулаан дамжуулах 8 төвийг барьж ашиглах төслийг “Энерго Сервис Монтаж” ХХК компани гүйцэтгэж байна.

Дундговь аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн ажлын гүйцэтгэгч “Энерго Сервис Монтаж” ХХК нь төслийн талбайд 2023.04 сард эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд доорх ажлуудыг гүйцэтгээд байна.

2023 оны 05 -р сарын 1 –нээс барилгын суурийн ажил, конвейер I, II, бутлуурын барилгын суурийн ажлууд эхэлсэн.

Конвейер I, II , бутлуурын барилга, харуулын байрны суурь, түлш хүлээн авах барилга, утаа сорогчийн барилгын суурь, цахилгааны барилгын суурь зэрэг үндсэн барилга угсралтын ажил 23 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуух угсралтын ажил нь 2023 оны 04-н сард эхэлсэн. Одоогийн байдлаар зуух 1,2-ын экран хоолой, циклон, эканомайзер, агаар халаагч зэрэг тоноглолуудыг угсарч дуусаад байна.

2023 онд төслийн гүйцэтгэл

Барилга угсралт 23 %

Зураг төсөв 70 %

Тоног төхөөрөмж ханган нийлүүлэлт 60 %

Нийт гүйцэтгэл 42 % тай явж байна.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “Энерго Сервис Монтаж” ХХК-ийн зүгээс доорх үндсэн чиглэлийг голлон хэрэгжүүлэн ажиллалаа.

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд
- Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд
- Хог хаягдлын менежментийн хүрээнд
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

2018 онд батлагдсан 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан байгаль орчны бүрдэл хэсгүүд бүрт тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, үндэслэл, баримтлан ажиллах дүрэм, стандартууд, зардлын хамт оруулсныг мөрдөж ажилласан.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Дулааны станцын барилгын ажилд ашиглаж байгаа бараа материал, тоног төхөөрөмжийн сав, баглаа, боодол, материалын ашиглахгүй болсон хэсэг, ажиллагсадын ахуйн гаралтай хол хаягдлаар газрын гадарга бохирдож болзошгүй.	Барилгын талбайд хог хаягдал хадгалах түр хогийн цэг байгуулсан. Хог хаягдлыг зориулалтын тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэж хаяж байна.	Төслийн хугацаанд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөвт багтсан	ХАБЭАБО алба
Барилгын ажлын үед ашиглаж байгаа тээврийн хэрэгслээс тос, шатахуун асгарч газрын гадарга, хэвлийг бохирдуулж болзошгүй.	Төслийн талбайд зогсоол байгуулж тээврийн хэрэгслийг байрлуулж байна. Төслийн талбайд автомашины засвар үйлчилгээ хийхийг хориглосон. Хэрэв ШТМ асгарсан тохиолдолд саарамгжуулах арга хэмжээг хурдан шуурхай авч хэрэгжүүлнэ.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Дулааны станц, дулаан дамжуулах шугам болон дулаан дамжуулах төвүүдийг барих явцад нийт 2.33 га талбайгаас нийт 0.4 тн ялзмагийн нөөц бүхий 3495 м ³ үржил шимт хөрс хуулагдаж, эвдэрнэ.	Барилгын ажил эхлэхийн өмнө хуулж авсан шимт хөрсийг овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтийн ажилд эргүүлэн ашиглахаар хадгалж байна.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба

Барилгажилтын үе: Жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн нүх, оромж нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын явцад амьтад устахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгах, амьтдыг эрсдэх орчноос үргээж холдуулах ажлыг хийсэн.		Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба
Дүн				

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан хогийн цэг байгуулан түр хадгалж байна.	Төслийн хугацаанд		-ХАБЭАБО алба
Ахуйн хог хаягдлыг тогтоосон хугацаанд нь тээвэрлүүлэх	Мандалговь хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байна.	7 хоног бүр	1.050.000	-Мандалговь хотын ОНӨААТҮГ -ХАБЭАБО алба
Газрын доорх усны чанар нөлөөлж болзошгүй хөрс бохирдуулахгүй байх, Хэрэглээнээс гарсан бохир усыг зориулалтын танканд хуримтлуулан татан зайлуулах.	Хэрэглээнээс гарсан бохир усыг Дундговь-Ус ОНӨҮ газартай гэрээ байгуулж татан зайлуулж байна,	7 хоног бүр	1.650.000	-Дундговь Ус ОНӨҮГ -ХАБЭАБО алба
Дүн			2.700.000	

НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Төслийн хувьд барилга угсралтын ажил нийтдээ 25,6 сарын турш үргэлжлэн, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн тул нөхөн сэргээлт, орчны тохижилттой холбоотой ажлуудыг 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаагүй учраас нөхөн сэргээлт, орчны тохижилтийн ажил 2023 онд хийгдээгүй.

Барилгын ажлын явцад болон дууссаны дараа нөлөөлөлд өртсөн газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулах, хөрс хуулалтаас хадгалсан өнгөн хөрсөөр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлт, орчны тохижуулалт болон явган хүний зам, автозамыг хатуу хучилттай болгох ажил хийгдэнэ.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Судалгааны хүрээнд тус аймагт дулааны станцын төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх, хувь хүн, аж ахуйн нэгж байхгүй болно.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд аймаг, сум, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Дундговь аймгийн Мандалговь хотод баригдах дулааны станцын төслийн үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар, археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй гэсэн үүрэг хүлээн ажиллаж байна.

ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

Төслийн бүхий л үе шатанд учирч болзошгүй аюул, осол эрсдлүүдийг урьдчилан тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхаарч ажиллаж байна.

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, боломжит бүх арга хэмжээг авах, Нийт ажилчдыг гал унтраах сургалтад хамруулах, Галын дохиолол, гал унтраагуур, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг байрлуулах, Төслийн талбайд галын дохиолол, аюулын гарц байрлалыг заасан самбар байрлуулах, галын дохиолол, гал унтраах хэрэгслийн тэмдэг санамж байрлуулах,	Галын аюулгүй байдлыг хангаж MNS 5566:2020 стандартын дагуу В ангиллын галын хор, галын сарайг хийж байршуулсан. Мөн төслийн барилгын шаардлагатай газруудад галын хор байршуулсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх, анхааруулах, санамж тэмдэг, самбаруудыг барилгын талбайд байрлуулсан.	Төслийн хугацаанд	2.600.000	ХАБЭАБО алба
Төслийн талбайд аюулгүй ажиллагааны бүх дүрэм журам болон аюултай бодистой холбоотой бусад бүх журмыг дагаж мөрдөх	Төслийн талбайд аюултай бодистой холбоотой бүх дүрэм журмыг мөрдөж, тэсэрч дэлбэрэх аюултай хийн баллонуудыг зориулалтын хадгалах саванд хийн аюулгүй байдлыг хангасан. Бусад бүх журмыг дагаж мөрдөн ажиллаж байна.	Төслийн хугацаанд		ХАБЭАБО алба
Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх	Яаралтай үед ашиглах анхны тусламжийн хайрцагийг байршуулж, шаардлагатай эм, тариа бусад хэрэглэлүүдээр хангасан.	Төслийн хугацаанд	2.800.000	ХАБЭАБО алба
Автомашинны осол	Автомашинны осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлж тээврийн хэрэгслийн авто зогсоол байгуулсан. Барилгын ажлын үед зорчих замыг засч замын хөдөлгөөний дүрмийн дагуу тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.	Төслийн хугацаанд	Үйл ажиллагааны зардал	ХАБЭАБО алба

Ажиллагсдын эрүүл мэнд	Ажиллагсдыг хүнс болон хэрэглээний усны чанарт анхаарч эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усыг хэрэглэж байна. Хэрэглээний цэвэр усыг 2023 оны 5 сард Дундговь аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн лабораторид нянсудлал, хими, хор судлалын шинжилгээнд хамруулсан.	Жилд 1 удаа	Орчны хяналт шинжилгээний зардалд багтсан	ХАБЭАБО алба
Дүн			5.400.000	

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД:

“ Энерго Сервис Монтаж ” ХХК-ийн Дундговь аймгийн Мандалговь хотод хэрэгжүүлж буй дулааны станц барьж ашиглах төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2023 оны БОМ-н төлөвлөгөөний дагуу хөрс, агаар, шинжилгээг жилд 1 удаа авч Дундговь аймгийн УЦУОШ газрын лабораторт, ундны уснаас хагас жил тутам дээж авч итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж байнгын хяналт тавин ажиллаж байна.

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах				
Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Авч хэрэгжүүлсэн ажлууд	Хугацаа	Зарцуулсан зардал	Хариуцан ажилласан
Хөрс				
Ерөнхий хими болон элементийн шинжилгээ	Дундговь Аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газарт төслийн барилгын талбайн 2 цэгээс дээж авч хөрсний шинжилгээ хийлгэсэн.	2023/05 сард	200.000	Дундговь аймгийн УЦУОШ Газар ХАБЭАБО
Дүн			200.000 төгрөг	
Ус				
Усны ерөнхий химийн шинжилгээ	Дундговь аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн лабораторт усны шинжилгээ өгсөн.	1 удаа	60.000	Дундговь аймгийн хэмжил зүйн лаборатори ХАБЭАБО
Хүнд элементийн шинжилгээ				
Бактериологийн шинжилгээ				
Дүн			60.000 төгрөг	
Нийт дүн			260.000 төгрөг	

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ТАЙЛАН

№	Менежментийн төлөвлөгөөний зардлын агуулга	Зарцуулсан зардлын хэмжээ, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	2.700.000
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	5.400.000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	260.000
Нийт		8.360.000

ДҮГНЭЛТ

Дундговь аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл эхэлснээс хойш аюул осолгүй, байгаль орчинд ээлтэй ажилласан байна. Энэ хугацаанд байгаль орчны эсрэг гарсан үл тохирол, зөрчилгүй ажилласан.

БОМ- н төлөвлөгөө боловсруулснаар хүн болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг цаг алдалгүй хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

- Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

- Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

- Байгаль орчны тухай хууль тогтоомжыг мөрдүүлэн ажиллаж байна.

Мандалговь хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

0823010012
Б А Т Л А В
МАНДАЛЫН ГЭГЭЭ ХОТ ААТҮГАЗРЫН
ДАРГА Д.ОЧБАДРАХ

Б А Т Л А В



ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 01 сарын 03 өдөр

Мандалговь хот

№

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээний гол зорилго нь Мандалговь хотын нутаг дэвсгэр дэх ААНБайгууллагын хог хаягдлыг тээвэрлэх, үүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Нэг талаас " Мандалын гэгээ Хот тохижуулах газар ААТҮГ" /цаашид Гүйцэтгэгч гэх/, Нөгөө талаас /цаашид Захиалагч гэх/-ын хог хаягдлыг тээвэрлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.3. Энэхүү гэрээг 2023 оны 01 сарын 03–ний өдрөөс 2023 оны 12 сарын 31–ний өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.4. Дундговь аймгийн Сайнцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталсан үнийн тарифыг дагаж мөрдөнө.

Хоёр. Захиалагчийн эрх үүрэг

- 2.1. Захиалагч нь гарсан хог хаягдлыг тээвэрлүүлэх, тээвэрлэхийг шаардах эрхтэй.
- 2.2. Захиалагч нь ямар ч тохиолдолд гарсан хог хаягдлыг зориулалтын бус газарт ил задгай хаяхыг хориглоно.
- 2.3. Захиалагч нь дараах шаардлага хангасан хогийн савтай байна. Үүнд:
 - ✓ хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн
 - ✓ галд тэсвэртэй материалаар хийгдсэн
 - ✓ хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байна.
- 2.4. Хог хаягдлын овор хэмжээг багасгаж хадгалах
- 2.5. Хуванцар сав, гялгар уут, лааз зэрэг дахивар хог хаягдлыг ангилах.
- 2.6. Аймгийн засаг даргын 2021 оны А/431 дугаар "Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч импортлогч нь хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтын хэрэгжилтийг хангах тухай" захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- 2.7. Дахин ашиглагдах боломжгүй хаягдлыг Хот тохижуулах газраар тээвэрлүүлэх

Мандалговь хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

- 2.8. Захиалагч нь хог хаягдлын сав дүүрсэн тохиолдолд захиалгаа ачиж тээвэрлэхээс нэг өдрийн өмнө өгсөн байх.
- 2.9. Тухайн ААН, байгууллага өөрийн талбай /хашаа/-аас гадагш **50 метр** зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй.
- 2.10. Цас орж, мөс тогтсон бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж гарах хог хаягдлыг байнга тээвэрлүүлж байх.
- 2.11. Тухайн байгууллага ААНэгж нь хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.12. Хот тохижуулах газар болон орон нутгаас зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээний ажилд болон хог хаягдлыг ангилан ялгах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт семинарт бүх албан хаагчдыг хамруулах.
- 2.13. Захиалагч нь гарсан хог хаягдлын төлбөрөө тогтоосон тарифын дагуу цаг хугацаанд төлж байх үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 3.1. Гүйцэтгэгч нь захиалагчаас гарсан хог хаягдлыг заасан хуваарийн дагуу заасан хугацаанд саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 3.2. Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг нэхэмжлэх заасан хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.
- 3.3. Захиалагчаас хог ачих захиалга ирсэн тохиолдолд хоног хэтрүүлэлгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй
- 3.4. Хог хаягдлаа ачиж тээвэрлүүлэх захиалга өгсөн тохиолдолд тухайн байгууллагын хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
- 3.5. Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх үүрэгтэй.
- 3.6. Барилгын болон уурын зуухны үнс, нүүрсний хог хаягдлыг тусгай үнэ тарифаар ачиж тээвэрлэнэ.
- 3.7. Их хэмжээгээр гардаг уурын зуухны үнс нурмыг тухайн байгууллага өөрсдөө ачиж тээвэрлэх.

Мандалговь хотын тохижилт үйлчилгээний газартай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээ

Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

- 4.1. Гэрээт хугацаанд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр захиалагчийн хог хаягдлыг захиалгын дагуу ачиж тээвэрлэнэ.
- 4.2. Их хэмжээгээр гардаг уурын зуухны үнс нурмыг өөрсдөө ачиж тээвэрлэдэг байгууллагуудад баталсан үнийн тарифын дагуу төлбөр тооцоог нэхэмжилнэ.
- 4.3. Тухайн үнсийг хог хаягдлын цэгт асгаж буй /м³/ хэмжээгээр тооцож төлбөрийг нэхэмжилнэ.
- 4.4. Захиалагч нь хог тээвэрлэсний төлбөр хураамжийг6000 (м³)..... төгрөгөөр тооцон сар бүрийн 25-ны дотор Хаан банкны **100081400947** дансанд шилжүүлнэ.
- 4.5. Захиалагч нь төлбөр тооцоог улирал, хагас жил, жилээр төлж болно.
- 4.6. Хог хаягдлын хураамжийг хугацаа хожимдуулсан тохиолдолд хоног тутамд 0,5%-ийн алданги нэмж төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

- 5.1. Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.
- 5.2. Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

Зургаа. Бусад

- 6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Хуванцар сав, гялгар уут, дахивар хог хаягдлыг ангилж Баялаг төвийн байршил бүхий нэрийн хуудсыг гэрээнд хавсаргасан болно.
- 6.3. Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгчийг төлөөлж

Инженер:/Ж.Базарсад/

Утас: 88076529

Хог тээвэрлэлтийн захиалга өгөх, санал гомдлын

Утас: 70593906

Захиалагчийг төлөөлж


Нягтлан бодогч:/...../

Утас:

Усны шинжилгээний хариу

5/15/23, 12:51 PM

GASI-LIMS



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН

ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг.

Утас: 70592146

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/: 23-81

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр: ЭНЕРГО СЕРВИС МОНТАЖ ХХК

/The name of customer's request for analysis/

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/: Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори; Эрүүл ахуйн хими, хор судлалын хяналтын лаборатори

Дээжийн тодорхойлолт /Sample description/

Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цувралын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
453	Ундны ус		Монгол Улс	Тодорхойгүй	0.5 л
454	Ундны ус		Монгол Улс	Тодорхойгүй	1.5 л

Хүлээн авсан огноо Date of receipt	Шинжилгээ дууссан огноо Date of test completion	Хэвлэсэн огноо Date of issue of the report
2023 он 05 сар 09 өдөр	2023 он 05 сар 11 өдөр	2023 он 05 сар 15 өдөр

Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit	Шаардлага Test specification, unit	Шинжилгээний дүн Test results
453	MNS 6546:2015	<i>Pseudomonas aeruginosa</i>	100 /мл/-т илрэхгүй	илрээгүй
	MNS ISO 6222:1998	ББЕТ	1 /мл/-т ≤ 100	53 / $\pm 0,26$ /
	MNS ISO 19250:2017	<i>Salmonella spp</i>	25 /мл/-т илрэхгүй	илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гадзсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	100 /мл/-т илрэхгүй	илрээгүй
454	MNS ISO 7150:2006	Аммон	1,5 мг/л-ээс ихгүй	0,0 мг/л
	MNS 1097:1970	Кальци	100 мг/л-ээс ихгүй	67,1 мг/л
	MNS 1097:1970	Магни	30 мг/л-ээс ихгүй	27 мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0,3 мг/л-ээс ихгүй	0,0 мг/л
	MNS ISO 7890-3:2001	Нитрат	50 мг/л-ээс ихгүй	0,8 мг/л
	MNS 6779:2019	Нитрит	1 мг/л-ээс ихгүй	0,0 мг/л
	MNS ISO 10523:2001	pH	6,5-8,5	7,8
	MNS 6271:2011	Сульфат	500 мг/л-ээс ихгүй	307,3 мг/л
	MNS 6272:2011	Фтор	0,7-1,5 мг/л-ээс ихгүй	1,2 мг/л
	MNS 6778:2019	Хатуулаг	7 мг-экв/л-ээс ихгүй	5,6 мг-экв/л
MNS 4424:2005	Хлорид	350 мг/л-ээс ихгүй	79,9 мг/л	

Санал тайлбар:

Opinions and interpretation

БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН

Approved by ЭРХЛЭГЧ:



/С.БАТБААТАР/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.

Хөрсний шинжилгээний хариу



УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ЛАБОРАТОРИ

Дундговь аймаг Сайнцагаан сум 7-р баг бага тойруу 2-200
Утас/Факс: 70592350, 88819335
E-mail хаяг tsaguur@dundgovi.gov.mn



Сорьцын дугаар: S/21, S/22
Сорьц авсан газрын нэр, хаяг, утас: Сайнцагаан сум Энерго сервис монтаж ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал: БОШЛ-ийн техникч М.Баярмаа
Сорьцын тоо, хэмжээ: 2, 0.5 кг
Сорьцын төрөл: Хөрсний агрохимийн шинжилгээ
Сорьц авсан огноо: 2023.08.01
Лабораторид хүлээж авсан : 2023.08.01
Шинжилгээ эхэлсэн огноо: 2023.08.07
Хэвлэсэн огноо: 2023.08.10
Хуудасны тоо: 1/1

ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Сорьц авсан цэг: Энерго сервис монтаж ХХК- ний Мандалговь хот дахь Дулааны станцын барилгын талбай		
Сорьцын дугаар	S/21	S/22
Хөрсний чанарын үзүүлэлтүүд	Эрүүл хөрс	Ашиглалтын талбай
pH	7.701	7.753
Ялзмаг %	1.57	0.66
NO ₃ мг/кг	5.6	7.5
NH ₄ мг/кг	9.7	29.0
SO ₄ мг/кг	24.05	12.66
P ₂ O ₅ мг/кг	илр	илр

Тайлбар: илр-илрээгүй

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН
БОШ ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ /Б.ЯНЖМАА /

ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ
БОШЛАБОРАТОРИЙН ИНЖЕНЕР /Э.БУЯНДЭЛГЭР/



Бохир ус соруулах гэрээ

БАТЛАВ.
ДУНДГОВЬ-УС ОНӨҮГ-ЫН

ЗАХИРАЛ *О.А.Т.* /О. БАРХҮҮ/



2023 оны 6 сарын 5 өдөр

БАТЛАВ
“ЭНЕРГО СЕРВИС МОНТАЖ” ХХК-НЫ
ТӨСӨЛ ХАРИУЦСАН
ЗАХИРАЛ *Ш.Төрбат* /Ш.ТӨРБАТ/

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№

Мандалговь хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол улсын иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн нэг талаас Дундговь-Ус ОНӨААТҮГ-ыг төлөөлж нягтлан бодогч ажилтай /Б.Сумъяасүрэн/ /цаашид “түрээслүүлэгч” гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас Энерго сервис монтаж ХХК-ны тооцооны менежер “түрээслэгч” захиалагч гэх/ нар энэхүү гэрээг харилцан тохиролцож байгуулав.

2. Энэхүү гэрээний зорилго нь “Энерго сервис монтаж ХХК”-ны бохир ус соруулж, зөөвөрлөх ажлыг гүйцэтгэхэд ДУА 23-28 ДУА улсын дугаартай HUVEL CLW7051 маркын бохир ус соруулах тусгай зориулалтын автомашиныг түрээсээр ажиллуулах болон төлбөр тооцоотой холбогдон гарах харилцааг зохицуулахад оршино.

3. Гэрээг мөрдөж эхлэх хугацаа 2023 он 6 сарын 5 өдөр

.....

Хоёр. Төлбөр тооцоо

1. Уг автомашины бохир ус соролтын рейс, нэг удаагийн рейсны үнэ..... төгрөг, нийт..... / / төгрөгийг ажил бүрэн дууссаны дараа байгууллагын нэхэмжлэлээр Түрээслүүлэгч талын Хаан банкны **5450032432** тоот дансанд шилжүүлнэ.

2. Зайлшгүй шаардлагаар түрээслэгч ШТМ-аар хангасан тохиолдолд түрээслүүлэгч түүний үнийг хасч тооцоо хийнэ.

3. Ажил 100% бүрэн дууссаны дараа гүйцэтгэлийг дүгнэж харилцан тооцоо нийлж санхүүгийн баримтыг бүрдүүлнэ.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

1. Түрээсийн механизмыг гэрээт хугацаандаа зориулалтын дагуу ашиглана.

2. Захиалагч гэрээнд заасны дагуу төлбөрийг гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх үүрэгтэй.

3. Машин механизм нь захиалагчийн ажил гүйцэтгэх шаардлагыг хангаж чадахааргүй бол түрээслэгчид хандаж гэрээгээ хугацаанаас өмнө цуцлах эрхтэй.

4. Захиалагч нь машин, механизмыг бусдад давхар түрээслүүлэх, дамжуулан ашиглуулах, барьцаалахыг хориглоно.

5. Түрээсийн механизмыг бохир ус соруулах, зөөвөрлөх ажилд захиалагчийн хяналт тавина.

6. Цэцэрлэгийн бохирын цооногоос бохир ус соруулах ажлыг түргэн шуурхай, чанартай гүйцэтгэхийг шаардах, уг ажлыг бүрэн дуусгуулж хүлээн авч, төлбөг тооцоог барагдуулна.

Бохир ус соруулах гэрээ

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

1. Гүйцэтгэгч тал механизмыг ажиллуулах ажлын дадлага, ур чадвартай, мэргэжлийн жолоочоор найдвартай хангана.
2. Механизм ажиллуулах үеийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллах ба түүнтэй холбогдсон асуудлыг бүрэн хариуцна.
3. Механизмыг ажиллуулах хугацаанд үүссэн аливаа эвдрэл, гэмтлийг өөрийн зардлаар түргэн шуурхай гүйцэтгэх үүрэгтэй.
4. Машин механизмын ашиглалтын хугацаанаас хамаарсан техникийн үйлчилгээ / тос, тосол / болон холбогдох зардлыг хариуцна.
5. Гүйцэтгэгч тал нь түрээслэгчийн ажлын хугацааны график, ажлын цаг, дотоод журмыг мөрдөж ажиллах үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллана.
6. Механизмын тээврийн гэрчилгээний хуулбар хувийг захиалагч талд өгнө.

Тав. Гэрээ сунгах, цуцлах журам

1. Захиалагч нь гэрээний хугацаа сунгах тухайгаа гэрээний хугацаа дуусахаас ажлын 2 хоногийн өмнө мэдэгдэнэ.
2. Гэрээг сунгах талаар түрээслэгчид мэдэгдээгүй тохиолдолд гэрээний хугацааг дууссанд тооцно.

Зургаа. Бусад зүйл

1. Хэрэв гэрээний хэрэгжилтийн явцад маргаантай асуудал гарвал талууд эв зүйгээр шийдвэрлэх бөгөөд хэрэв тохиролцоонд хүрэхгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.
2. Гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба тухайн ажлын талаар өмнө ярилцаж байсан асуудлууд хүчингүй болж зөвхөн гэрээний хүрээнд асуудлыг шийдвэрлэнэ.
3. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

Гүйцэтгэгчийг төлөөлж :

Захиалагчийг төлөөлж :

Ня-бо



/Б.Сумъяасүрэн/

тооцооны менежер

/Г.Насанжаргал/

Утас : 89616605

Утас : 89543379

РД :3427951

РД:2656477

Гэрээ дүгнэсэн байдал :

.....
.....

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧЛОЛ

1	Дундговь Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газарт төслийн барилгын талбайн 2 цэгээс дээж авч хөрсний шинжилгээ хийлгэсэн.
2	Дундговь аймгийн стандарт хэмжил зүйн итгэмжлэгдсэн лабораторт усны шинжилгээ өгсөн.
3	Бараа материал ачсан тээврийн хэрэгсэл нь зөвхөн заасан маршрутын дагуу явж зогсоолын талбайд байршуулж байна
4	Хог хаядлыг зориулалтын дагуу тээвэрлэн хаяж байна. Гэрээ хийгдсэн.
5	Ахуйн хатуу хог хаягдлыг байршуулах тусгай хогийн цэг байршуулсан
6	Галын аюулгүй байдлыг хангаж MNS 5566:2020 стандартын дагуу В ангиллын галын сарайг хийж байршуулсан.
7	Шимт хөрсийг хуулан авч тусгай овоолгын талбайд хадгалж байна.
8	Барилгын ажилд ашиглаж байгаа техникийг хуваарийн дагуу үзлэгт оруулж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангуулан ажиллаж байна.
9	Тээврийн хэрэгслээс ШТМ асгарахаас сэргийлж шингээх материал худалдан авах захиалга хийсэн.

